

## ГАРЧИГ

|  |    |
|--|----|
| <b>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....   | 2  |
| 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл .....   | 2  |
| 1.2 Ордын нөөцийн тооцоо .....   | 5  |
| 1.3 2022 оны жилийн хүчин чадал, ашиглах хугацаа .....   | 6  |
| <b>БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН<br/>ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....            | 7  |
| <b>БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ<br/>ТОДОРХОЙЛОЛТ</b> .....  | 9  |
| 1.4 Байгаль орчинд учруулах нөлөөллийн үнэлгээ .....   | 9  |
| <b>БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....  | 11 |
| 1.5 Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах<br>хүрээ   | 11 |
| 1.6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....   | 12 |
| 1.7 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....   | 13 |
| 1.8 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .   | 13 |
| 1.9 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....   | 14 |
| 1.10 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....   | 14 |
| 1.11 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....  | 14 |
| 1.12 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....  | 15 |
| 1.13 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр .....  | 16 |
| 1.14 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага<br>зохион байгуулалтын төлөвлөгөө .....               | 18 |
| 1.15 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг<br>нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө. .... | 18 |
| <b>БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ</b>   |    |
| 21   |    |

**БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

**1.1 Төслийн ерөнхий мэдээлэл**

|   |   |                    |             |
|---|---|--------------------|-------------|
| ТӨСЛИЙН НЭР:  | “ЯМААТ” нэртэй хайлуур жоншны ордыг ашиглах далд уурхайн болон баяжуулах үйлдвэр төсөл  |                    |             |
| ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР:<br>УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ: РЕГИСТРИЙН<br>ДУГААР: | “Зэвт дуулга” ХХКомпани<br>9011046069<br>5101883  |                    |             |
| ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:   | Улаанбаатар хот, Хан-Уул, 2-р хороо, ГУТАЛ<br>ОФФИС 303 тоот<br>Харилцах утас: 99791024, 342318   |                    |             |
| АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ<br>ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:                          | MV-017189 /148.43 га/   |                    |             |
| ТӨСЛИЙН БАЙРШИЛ:  | Ямаатын (Ковалевын) хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Батноров сумын төвөөс баруун хойт зүгт 7.0 км-ийн зайд, орой нь д.т.дээш 1146.8 м-ийн үнэмлэхүй өндөржилттэй жижиг толгойн баруун урд хажууд оршино. |                    |             |
| Үзүүлэлтүүд   |   | Нэгж               | Тоо, хэмжээ |
| Ордын геологийн нөөц:   | В зэрэглэлээр   | мян.тн             | 50.6        |
|   | С зэрэглэлээр   | мян.тн             | 60.7        |
|   | В+С   | мян.тн             | 111.2       |
|   | Дундаж агуулга: CaF <sub>2</sub>  | %                  | 69.63       |
| Ашиглалтын блок дахь геологийн нөөц:  | В зэрэглэлээр   | мян.тн             | 50.6        |
|   | С зэрэглэлээр   | мян.тн             | 52.7        |
|   | В+С   | мян.тн             | 103.2       |
|   | Дундаж агуулга: CaF <sub>2</sub>  | %                  | 70.31       |
| Хаягдал   | Ашиглалтын  | мян.тн             | 14.0        |
|   | Хамгаалалтын цул  | мян.тн             | 15.2        |
|   | Нийт  | мян.тн             | 29.1        |
| Бохирдол  |   | %                  | 18.8        |
| Үйлдвэрлэлийн нөөц:   |   | мян.тн             | 95.1        |
| Үйлдвэрлэлийн нөөц дэх дундаж агуулга:  |   | %                  | 59.79       |
| Уурхайн жилийн хүчин чадал  |   | мян.тн             | 20          |
| Ажиллах горим: - жилд ажиллах хоног   |   | Хоног              | 330         |
| - хоногт ажиллах ээлж   |   | Ээлж               | 3           |
| ээлж үргэлжлэх хугацаа: - газрын доор   |   | Цаг                | 7           |
| - газрын дээр   |   | Цаг                | 8           |
| Ашиглалтын систем: хүдэр хоршоолох, туушид нураах ашиглалтын систем             |   |                    |             |
| Ордыг нээх арга: босоо гол ам, нөөц гарц - блокийн восстающийнууд               |   |                    |             |
| Ажиллагсдын тоо   |   | Хүн                | 101         |
| Ордыг ашиглах хугацаа   |   | Жил                | 5           |
| Уулын ажлын хэмжээ: - Уулын үндсэн ажил (УҮА)                                   |   | мян.м <sup>3</sup> | 5.0         |
| - Уулын бэлтгэл ажил (УБА)  |   | мян.м <sup>3</sup> | 12.3        |
| - Цэвэрлэгээний ажил  |   | мян.м <sup>3</sup> | 26.6        |
| - Уулын цулаар  |   | мян.м <sup>3</sup> | 43.8        |
| Нийт зардал   |   | сая.төг            | 47150.8     |
| 1тн баяжмалын бүрэн өөрийн өртөг  |   | Төг                | 655580      |
| Борлуулалтын орлого   |   | сая.төг            | 63047.3     |
| Цэвэр ашиг  |   | сая.төг            | 14306.8     |
| Нийт хөрөнгө оруулалт   |   | сая.төг            | 3594.4      |
| Хөрөнгө оруулалт нөхөн төлөх хугацаа  |   | Жил                | 1.2         |

|   |               |         |         |
|---|---------------|---------|---------|
| Улсын төсөвт оруулах хөрөнгө                        |               | сая.төг | 10142.1 |
| Ашгийн дотоод норм IRR                              |               | %       | 79%     |
| NPV, 10%  |               | сая.төг | 7380.7  |
| Перфоратор  | ПР-20         | Шир     | 5       |
| Перфоратор  | ПТ-36         | Шир     | 2       |
| Ачигч   | STB-60        | Шир     | 1       |
| Скрепер   | 30ЛС-2СМА     | Шир     | 1       |
| Гурван дугуйт трактор, 1.2м <sup>3</sup>            | ZY-155        | Шир     | 4       |
| Скип  | 1НОВ255-3.2   | Шир     | 1       |
| Насос   | ЦНСг-38-198   | Шир     | 2       |
| Насос   | ЭЦВ 4-6,5-130 | Шир     | 1       |
| Ерөнхий агааржуулалтын сэнс                         | ВЦ-11         | Шир     | 2       |
| Хэсэгчилсэн агааржуулалтын сэнс                     | ВОЭ 5         | Шир     | 5       |
| Өргөх тоног төхөөрөмж                               | ТЛ-7Б-1       | Шир     | 1       |
| Утгуурт ачигч ачигч 2017                            | ZL-25         | Шир     | 1       |
| Утгуурт ачигч ачигч 2007                            | ZL-50         | Шир     | 1       |
| Экскаватор  | XG822LC       | Шир     | 1       |
| DEAWOO фирмийн 15тн-ын<br>даацтай ачааны машин 1997 | Howo          | Шир     | 1       |

“Зэвт дуулга” ХХК Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Ямаат” нэртэй талбайд ашигт малтмал ашиглах MV-017189 тоот тусгай зөвшөөрлийг 2012 оны 10-р сарын 19-ний өдөр авсан.


Байр зүйн зургийн нэрэлбэр: М-49-139-Г ба L-49-7-Б

Талбайн хэмжээ: 148.49 гектар

*Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн солбицол*

| № | Уртраг WGS84 |     |       | Өргөрөг WGS84 |     |       | UTM         |             |
|---|--------------|-----|-------|---------------|-----|-------|-------------|-------------|
|   | Град         | Мин | Сек   | Град          | Мин | Сек   | Y           | X           |
| 1 | 111          | 27  | 20    | 48            | 0   | 13.47 | 533979.9017 | 5316816.491 |
| 2 | 111          | 27  | 20    | 47            | 59  | 41.76 | 533985.6864 | 5315837.484 |
| 3 | 111          | 25  | 50    | 47            | 59  | 41.76 | 532120.622  | 5315826.767 |
| 4 | 111          | 25  | 50    | 47            | 59  | 56.76 | 532118.0359 | 5316289.873 |
| 5 | 111          | 26  | 21.96 | 47            | 59  | 56.75 | 532780.2895 | 5316293.301 |
| 6 | 111          | 26  | 21.96 | 48            | 0   | 13.47 | 532777.3472 | 5316809.51  |

Зураг 1. Төсөл хэрэгжих газрын тойм зураг



Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн одоогийн төлөв (фото)



Зураг 3. Уурхайн тосгон





Зураг 4. Тэсрэх материалын агуулах




Зураг 5. Баяжуулах үйлдвэр



## 1.2 Ордын нөөцийн тооцоо

Ямаатын ордын хүдрийн Нөөцийн тооцооны гол үзүүлэлт болох нөөцийн зэрэглэл ба блок тус бүрээр дараалуулан дараах хүснэгтэд харуулав.

Зураг 6. Хүдрийн биет 1-ийн хэмжээ хавтгайд буулгасан нөөцийн тооцооны зураг



Хүснэгт 2. Ордын нөөцийн тооцоо

| № | Блок дугаар | Нөөцийн блокийн бодит талбайн хэмжээ, м <sup>2</sup> | Судлын өргөн, м | Хүдрийн биетийн эзэлхүүн, м <sup>3</sup> | Хүдрийн эзэлхүүн жин, тн/м <sup>3</sup> | Хүдрийн нөөц (2012 оны 5-р сарын 01-ний байдлаар) |                      |           | Хүдрийн нөөц 2020 оны 1-р сарын 01-ний байдлаар) |                      |           |
|---|-------------|--|-----------------|--|---|---|----------------------|-----------|--|----------------------|-----------|
|   |             |  |                 |  |   | Хүдэр, тн   | CaF <sub>2</sub> , % | Эрдэс, тн | Хүдэр, тн  | CaF <sub>2</sub> , % | Эрдэс, тн |
| 1 | 1B          | 10063.24   | 1.57            | 15799.29                                 | 2.7                                     | 42658.1   | 77.34                | 32991.8   | 40006.1  | 77.34                | 30940.7   |

|                               |    |          |      |          |     |          |       |         |          |       |         |
|-------------------------------|----|----------|------|----------|-----|----------|-------|---------|----------|-------|---------|
| 2                             | 2В | 2164.49  | 0.83 | 1796.53  | 2.7 | 4850.6   | 84.36 | 4092.0  | 4850.6   | 84.36 | 4092.0  |
| 3                             | 3В | 1570.56  | 0.72 | 1130.80  | 2.7 | 3053.2   | 78.59 | 2399.5  | 3053.2   | 78.59 | 2399.5  |
| 4                             | 4С | 6745.22  | 1.11 | 7487.19  | 2.7 | 20215.4  | 60.01 | 12131.3 | 20215.4  | 60.01 | 12131.3 |
| 5                             | 5С | 2205.69  | 0.80 | 1764.55  | 2.7 | 4764.3   | 50.41 | 2401.7  | 4764.3   | 50.41 | 2401.7  |
| 6                             | 6С | 3756.47  | 1.04 | 3906.73  | 2.7 | 10548.2  | 59.34 | 6259.3  | 10548.2  | 59.34 | 6259.3  |
| 7                             | 7С | 855.11   | 0.99 | 846.56   | 2.7 | 2285.7   | 74.94 | 1712.9  | 1285.7   | 74.94 | 963.5   |
| 8                             | 8С | 10573.58 | 0.80 | 8458.86  | 2.7 | 22838.9  | 67.67 | 15455.1 | 22838.9  | 67.67 | 15455.1 |
| Бодитой (В)                   |    | бүгд:    |      | 18726.62 | 2.7 | 50561.9  |       | 39483.2 | 47909.9  |       | 37432.2 |
|                               |    | дундаж:  | 1.36 |          |     |          | 78.09 |         |          | 78.13 |         |
| Боломжтой (С)                 |    | бүгд:    |      | 22463.90 |     | 60652.5  |       | 37960.3 | 59652.5  |       | 37210.9 |
|                               |    | дундаж:  | 0.93 |          |     |          | 62.59 |         |          | 62.38 |         |
| Нийт хүдрийн биетийн хэмжээнд |    | бүгд:    |      |          |     | 11121.44 |       | 77443.5 | 107562.4 |       | 74643.0 |
|                               |    | дундаж:  | 1.09 |          |     |          | 69.63 |         |          | 69.40 |         |

Дээр тооцоолсон нийт 111.2 мян.тн хүдрийн нөөцөөс 2014-2015 онуудад 1В блокоос 2652 тн 2019 онд 7С блокоос 1000.0 тн хүдрийг олборлосон байна.

2020 онд Ковид -19 Цар тахлын улмаас ажиллаж чадаагүй бөгөөд Ажилласан хугацаа маш бага бөгөөд түүнд бэлтгэл ажил хийсэн болно.

Иймд 2021 оны 1-р сарын 01-ний байдлаар бодитой болон боломжтой зэргээр (В+С) тооцсон СаF<sub>2</sub>-ын 69.40 %-ийн дундаж агуулгатай 107.56 мян.тн хүдрийн нөөцийг далд уурхайн аргаар ашиглана.

2022 онд хил гаалийн хаалтай байдал улмаас ажиллаж чадаагүй бөгөөд Ажилласан хугацаа маш бага бөгөөд түүнд бэлтгэл ажил хийсэн болно.

### 1.3 2023 оны жилийн хүчин чадал, ашиглах хугацаа

2022 онд манай уурхай нь эдийн засгийн байдлаас үүдэн олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй ба Батноров сумын засаг даргаас үйл ажиллагаа явуулаагүйг нотлох албан тоот авч баталгаажуулсан.

Харин төлөвлөгөөт 2023 онд уурхайн хүдэр олборлолтын жилийн хүчин чадлын хэмжээг уул-техникийн нөхцөлд тааруулан гар аргаар ангилан **2,0 мян.тн** хүдрийг, тусгай аргын 3076.9 тн баяжмал борлуулахаар тооцож уулын ажлын төлөвлөлтийг хийсэн байна.

Хүдрийн биет судал №1-ийн налуувтар уналтай баруун хэсэгт “туушид олборлох ашиглалтын систем”, харин харьцангуй эгц уналтай зүүн хэсэгт “хоршоолсон систем”-р ажиллана.

Далд уурхайн ажиллах горим нь жилд 330 хоног тасралтгүй олборлолтын ажил явуулан хоногт 3 ээлжээр ажиллана. Ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг байна.

**БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ  
 ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

| № | Байгаль орчны бүрдэл           | Товч тайлбар  |
|---|--------------------------------|---|
| 1 | Физик газарзүйн нөхцөл         | Хэнтийн уулархаг мужийн зүүн өмнөд хэсгийн Дорнод Монголын тэгш талд шилжиж буй тал хээрийн бүсэнд хамаарагдана. Уул зүй ба гадаргуугийн хэлбэр. Хайгуулын талбай бүхэлдээ намхан толгодлог гадаргуутай, төвийн хэсэгт орших хойноос урагш цуварсан жижиг толгод нь баруун ба зүүн талаараа өргөн хөндийгөөр хязгаарлагддаг. Ямаатын орд нь хайгуулын талбайн урд захад, 1146.8 м-ийн өндөржилттэй жижиг толгойн баруун урд хажууд оршдог.  |
| 2 | Цаг уур уур амьсгал            | Өвлийн улиралд ихэнхдээ -150 - -210С, жилийн 12 сар ба 1-р сард заримдаа -37.5 - -41.50 С хүртэл хүйтэрдэг. Зуны улиралд ерөнхийдөө халуун, хуурайдуу уур амьсгалтай байх ба 7, 8-р сард +200 - +300С, хамгийн халуун +39 0С хүрч байжээ. Жилд буух хур тунадасны хэмжээ дунджаар 150 мм, агаарын чийгшил нь зуны цагт буух хур тунадаснаас шалтгаалах бөгөөд харьцангуй чийгшил 50%-иас хэтрэхгүй. Анхны цас 9-р сарын дундуур болон 10-р сарын эхээр орох ба 4-р сарын төгсгөл болтол цас бүрэн хайлж дуусахгүй. Салхины хурд тогтмол 4.4 -10 м/сек байдаг боловч өвөл, хаврын цагт зарим үед 28м/сек хүртэл хурдтай шуургадаг.           |
| 3 | Агаарын чанар                  | 2021 онд агаарын шинжилгээ 2 цэгт хийсэн ба гарсан дүнгээс харахад агаарт дахь SO2, NO2- ийн хэмжээ нь MNS 4585:2016 стандарт хэмжээг давсан үзүүлэлт байхгүй хэвийн хэмжээнд байсан. Мөн ашиглалтын талбайд нийт 2 цэгт нийт тоосжилтыг хэмжсэн. Тухайн хэмжилтийн дүнг MNS 4585:2016 стандарт үзүүлэлтэй харьцуулахад агаарт агуулагдах нийт тоос хэвийн/маш бага/ хэмжээнд гэсэн үр дүн гарсан байна.  |
| 4 | Гадаргын болон газрын доорх ус | 2021 онд усны дээжлэлтийг 1 цэгт Хэнтий аймгийн УЦЦОШГ-ын ЦУОТХ-ийн БОШЛ-ийн техникч Б.Ганганбайгал дээжлэлт авсан бол лабораторийн шинжилгээг Б.Шүрэнчимэг хийсэн байна. Усны шинжилгээний дүнгүүдийг “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 900:2005”, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS4586:1998”, “Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010” стандартуудтай харьцуулахад, стандарт хэмжээг давсан үзүүлэлт ажиглагдаагүй байна.   |
| 5 | Хөрсөн бүрхэвч                 | Талбайн хөрсний шинжилгээний дүнгээр доор карбонаттай хар хүрэн хөрснөөс бусад хөрсний дээд А ялзмагт давхаргад ялзмагийн агууламж дунд зэрэг агуулагдсан, үе давхарга доошлоход эрс бууралттай байна. Хөрсний урвалын орчин сул шүлтлэг, доод давхаргад шүлтжилт илүүтэй, цахилгаан дамжуулах чанар сул, хөрсөнд ямар нэгэн давслагийн зүйл байхгүй, карбонаттай хар хүрэн хөрсний доод давхаргад карбонаттай байгаагаар ялгаатай. Хөрсөн дэх шингээгдсэн сууриудын нийлбэр хангалттай, катионоос кальцийн ион давамгайлсан, ургамалд хялбар ашиглагдах хөдөлгөөнт фосфороор дунд зэрэг, калийн агууламжаар дундаас доош хангамжтай байна. |
| 5 | Амьтны аймаг                   | Ан, амьтнаар бага, элбэг тохиолдох махчин амьтдаас хярс, мануул, чоно, мэрэгчдээс цагаан оготно, олби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Жигүүртнээс бүргэд, элээ, хэрээ, шар шувуу, болжмор, ногтруу, ууль, хөх цөцгий, тагтаа, чогчиго зэрэг шувууд, хэвлээр явагчаас могой, бусад хорхой шавж их байдаг.  |

|   |                                  |  |
|---|----------------------------------|--|
| 6 | Ургамлын аймаг                   | Уурхайн талбайн ойр орчимд ховор болон нэн ховор ургамал бүртгэгдээгүй байна. Хуурай хээр, дундаж өндөр ба нам уулсын бэл, ухаа толгод, тал газрын хазаар өвс хялганат эвшил зонхилсон бөгөөд жижиг үетэн хялганат, чулуусаг алаг өвс ботуульт, алаг өвс-жижиг үетэнт, үетэн-улалж-ботуульт, өдлөг хялганат, өдлөг-хялгана-таана-бударганат, өдлөг хялгана-бударганат, зэрэг эвشلүүд тархсан хээрийн ургамалжилттай.   |
| 7 | Тусгай хамгаалалттай газар нутаг | Хэнтий аймгийн Батноров сумын нутагт Улсын тусгай хамгаалалттай газар байхгүй байна. Харин төсөл хэрэгжих талбайн урд хилээс 35 км зайд Хар ямаат байгалийн нөөц газар, 55 км-т Тосон хулстай хэмээх байгалийн нөөц газар оршдог байна. Мөн Батноров сум нь аймгийн тусгай хамгаалалттай 32 газар, сумын тусгай хамгаалалттай 14 газар нутаг байдаг байна. Үүнээс төсөл хэрэгжих талбай хамгийн ойр орших газар нь 2 км зайд сумын тусгай хамгаалалт бүхий Салхитын цагаан толгой орших бол 5-7 км зайд аймгийн тусгай хамгаалалт бүхий Зүүн салхитын булш, Жавхлант, Эрдэнэ уулын дурсгал, Шанага уулын баруун зэрэг газрууд байна.   |
| 8 | Нийгэм эдийн засаг               | Батноров сум нь 496829 га газар нутагтай. Үүнээс: Бэлчээр 475352 га, газар тариалан 947 га, хадлан 13700 га, хот суурин бусад суурин газар 1113 га, ойн сав бүхий газар 1041 га, усан сан бүхий газар 1245 га. Монгол орны тал хээрийн бүсэд оршдог. Хойд цэгээс урд цэг хүртэл 118 км, баруунаас зүүн зүг хүртэл 74 км буюу хойноосоо урагш сунаж тогтсон газар нутагтай. Нийт 5466 хүн амтай. Эрдэнэчандмань, Эхэнбүрд, Баян, Баянбулаг, Идэрмэг, Дундбүрд, Бэрх гэсэн 7 багтай. Хэнтий аймгийн Баян-Овоо, Норовлин, Биндэр, Баян-Адрага, Баянхутаг, Хэрлэн гэсэн 6 сумтай хиллэдэг. Улсын чанартай сайжруулсан шороон зам Өндөрхаанаас Батноров, Норовлин, Баян-Уул сумуудаар дайрч Оросын хил Ульханы боомт хүрнэ  |
| 9 | Дэд бүтэц.                       | Ямаатын талбай нь манай орны эдийн засгийн зүүн бүсийн дэд бүтэц эрчимтэй хөгжиж буй нутагт багтдаг. Улаанбаатар хотоос зүүн тийш 440 км, Чингис хотоос зүүн хойш 110 км зайтай оршдог. Томоохон хот суурин, үйлдвэр аж ахуйгаас алслагдмал, хүн ам цөөн ч гэсэн зам харилцаа харьцангуй сайн хөгжсөн газрын нэг мөн. Улаанбаатараас 330 км хатуу хучилттай замаар явж Чингис хот өнгөрөөд 20 км мөн хатуу хучилтай замаар яваад сайжруулсан замд орж Бэрх тосгон хүртэл 45км явна. Бэрх тосгоноос 30 км сайжруулсан замаар Батноров сумын төв хүрнэ. 2021-2022 онд Батноров, Норовлин, Дадал сумууд хатуу хучилтай болохоор төлөвлөгдсөн байгаа. Батноров сумаас баруун хойно 7 км Ямаатын уурхай оршино.<br>Уурхайгаас баруун хойш 5 км Чингис хаан болон Хөлөг Боорчийн “Андлалын өргөө” гэх аялал жуучлалын бүс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа болно. |



### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 1.4 БАЙГАЛЬ ОРЧИНД УЧРУУЛАХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

##### Аргачлал

Магадлан жагсаах арга буюу хяналтын хуудасны арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм. Энэ аргын үр дүн төслөөс хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтооно.

Харин матрицын арга бол тухайн төслийн үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явцад байгаль орчин учруулах эерэг, сөрөг нөлөөллийг уялдуулан авч үзэж, нөлөөллийг бүрэн тодорхойлох боломж өргөнтэй арга юм. Үр дүн нь мөр болон баганын нийлбэр тоон үзүүлэлт нь цаашид төслийн аль үйл ажиллагаа эсвэл орчны аль хэлбэрт илүү анхаарал тавихыг тогтооход ашиглагдана.

*Хүснэгт 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал*

| Байгаль орчны үзүүлэлтүүд   | Шууд | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
|---|------|----------|---------------------|------------------|---------------|----------------|--------------------|--------|------------|------------|
| <b>Байгалийн экосистемийн өөрчлөлт</b>  |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Газрын доорх урсцын өөрчлөлт  |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Гадаргын усны урсцын өөрчлөлт   |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт   | +    |          |                     | +                |               | +              |                    | +      |            |            |
| Хөрсний элэгдэл, эвдрэл   | +    |          |                     | +                |               |                | +                  | +      |            |            |
| Геологийн тогтцын өөрчлөлт  | +    |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Зэрлэг амьтдын орон зай   |      | +        |                     | +                |               |                |                    |        |            | +          |
| Уур амьсгалын (бичил)   |      | +        | +                   | +                |               |                |                    |        |            | +          |
| <b>Байгалийн нөөц, ашиглалт</b>   |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Газрын доорх нөөц баялаг  | +    |          |                     | +                |               |                |                    | +      |            |            |
| Бэлчээрийн байдал   | +    |          |                     | +                |               |                |                    | +      |            |            |
| <b>Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>   |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Газар доорх усны чанарын өөрчлөлт   |      | +        |                     | +                |               |                |                    |        |            | +          |
| Гадаргын усны чанарын   |      | +        |                     | +                |               |                | +                  |        |            | +          |
| Агаарын бохирдол  |      | +        |                     | +                |               |                | +                  |        |            | +          |
| Хөрсний бохирдол  | +    |          |                     | +                |               | +              |                    |        | +          |            |
| Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх                                     |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Дуу чимээ, шуугианы нөлөө   | +    |          |                     | +                |               |                |                    |        |            | +          |
| <b>Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b> |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх  | +    |          |                     |                  | +             |                | +                  | +      |            |            |

|  |           |          |          |           |          |          |          |          |          |           |
|--|-----------|----------|----------|-----------|----------|----------|----------|----------|----------|-----------|
| Ландшафтын хэлбэр, өнгө<br>өөрчлөгдөх  |           |          |          |           |          |          |          |          |          |           |
| Тусгай хамгаалалттай газар<br>нутагт нөлөөлөх  |           |          |          |           |          |          |          |          |          |           |
| Түүх соёлын дурсгалт зүйлд<br>нөлөөлөх   |           |          |          |           |          |          |          |          |          |           |
| Археологи, палеонтологийн<br>олдворт нөлөөлөх  |           |          |          |           |          |          |          |          |          |           |
| <b>Эдийн засаг, нийгмийн асуудал</b>   |           |          |          |           |          |          |          |          |          |           |
| Орон нутгийн орлого нэмэгдэх   | +         |          |          | +         |          |          | +        |          |          | +         |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг<br>болох  |           | +        |          | +         |          |          | +        |          |          | +         |
| Ажлын байр нэмэгдэх  | +         |          |          | +         |          |          | +        |          |          | +         |
| Улирлын чанартай эрэлт<br>хэрэгцээ нэмэгдэх  | +         |          |          | +         |          |          | +        |          |          | +         |
| Хүн амын эрүүл мэндэд  |           | +        |          | +         |          |          |          |          |          | +         |
| <b>Бусад нөлөөлөл</b>  |           |          |          |           |          |          |          |          |          |           |
| Үйлдвэрийн барилга<br>байгууламжийг барих үед орчны<br>хөрсний эвдрэл, бохирдол гарах                                | +         |          |          | +         |          |          |          |          |          | +         |
| Ахуйн болон үйлдвэрийн бохир<br>ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд<br>нэвчиж, хөрс ба газрын доорх усыг<br>бохирдуулах | +         |          |          | +         |          | +        |          |          | +        |           |
| Химийн бодис, үйлдвэрийн<br>хаягдал, барилгын материалын<br>хаягдал зэргээс байгаль орчинд<br>сөргөөр нөлөөлөх       |           |          |          |           |          |          |          |          |          |           |
| Хүчтэй салхи, түймэр газар<br>хөдлөл, аянга цахилгаан  | +         |          |          | +         | +        |          |          |          |          | +         |
| <b>Дүн</b>   | <b>14</b> | <b>7</b> | <b>1</b> | <b>19</b> | <b>2</b> | <b>3</b> | <b>8</b> | <b>5</b> | <b>2</b> | <b>13</b> |

---

#### **БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

---

##### **1.5 Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, ХАМРАХ ХҮРЭЭ**

---

Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт орших “ЯМААТ” нэртэй хайлуур жоншны ордыг ашиглах далд уурхайн болон баяжуулах үйлдвэр төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс уурхайн үйл ажиллагаатай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлөө.

